

Миний мэдэх Оюу Толгой

Өнөөдөр бид цагдаа дэлгүүрээс тамхи ширхэглэж авдаг, 00 цагаас хойш бар нь ажиллахын зэрэгцээ 21 нас байтугай 18 нас ч хүрээгүй хүүхдүүдэд үйлчилдэг ийм шударга бус нийгэмд амьдарч байж ганц үнэн шударга зүйлрүүгээ дайраад байгаа юм шиг санагдлаа.

Миний багийн нэг сайн найз байдаг юм. Тэр найз минь арван жил (ЕБС)- ээ онц дүнтэй төгсөж конкурс (ЭЕШ) амжилттай өгч анагаах (ЭМШУИС)-ийн их эмчийн ангийн хуваарийг авсан юм. Намар нь хотруу ирээд сургуульдаа элсэн орж суралцсан ч II семестрээс төлбөрөө төлөх боломжгүйн улмаас сургуулиасаа гарч аймагтаа буцаж очоод бар-нд зөөгчөөр ажиллах болсон. Намайг зун очиход бармен болж дэвшсэн хэдий ч архи дарстай тийм газар удаан ажиллахаараа хүн өөрийн мэдэлгүй балгах дуртай болчихдог юм шиг ээ. Хааяа нэг балгах ч биш орой болгон ажлаа тараад л архи пиво уудаг болсон байлаа. Сүүлд сонсоод байхад найз охин нь жирэмсэн өнөө маргаашгүй төрөх дөхсөөр байтал барнаас авдаг цалин 180000 төгрөгөөрөө тэр чигт нь уучихдаг сураг дуулдаад их санаа зовж байв. Тэгтэл Дорнод аймгийн Шаталсан сургалттай Техник Технологийн сургууль одоо Политехник коллеж болсон тэнд нэг жилийн хугацаатай, 210000 төгрөгний цалинтай, Оюу Толгойд ажилчин бэлтгэх сургалт явагдаж манай найз ажилаасаа гараад тэнд сууж байгаа гэж сонслоо. Өвөлийн амралтаараа Дорнодруу очихдоо найзтайгаа уулзахад эхнэр нь төрсөн хүү охин хоёр хүүхэдтэй болсон ажлаасаа гараад архи пиво хэрэглэх хүсэлгүй болсон амьдрал гоё байнаа сардаа 210000 төгрөгний цалин маань болж л байна одоо төгсөөд шууд Оюу Толгойд очиж ажиллана сая гаргаад л цалин авна даа гэж ярьж билээ. Бид хоёрын ийнхүү яриад зогсож байтал найзын маань ангийн нэг оюутан ирсэн нь арван жилд манай ангид түүх, нийгмийн хичээл ордог байсан багш байлаа. Би гайхаад багшаа та яагаад энэ сургалтанд сууж байгаа юм бэ? Гэж асуухад багшийн цалингаар амьдрах хэцүү юмаа бага байна. Жил сураад шууд бэлэн ажлын байртай Оюу Толгойд багшийн цалингаас 3, 4 дахин өндөр цалин авна шүү дээ. Тэдний ангид хотод сурч байгаад ирсэн оюутнууд тав зургаа байлаа. ШУТИС-ийн инженерийн ангийн оюутан хүртэл II курсээсээ сургуулиасаа гараад ирж сурч байгаа гэж байсан.

Одоо манай найз Дорнодоос Улаанбаатарлуу машинаар ирээд Улаанбаатараас Оюу Толгойруу онгоцоор явдаг. (Удахгүй Оюу Толгой – Дорнод, Дорнод Оюу Толгой гэсэн нислэгтэй болно гэсэн одоо бараг болчинсон байх) Тэгээд 15 хоног ажилаад сая гаран төгрөгний цалин аваад буцдаг. Харьж 15 хоног амарчихаад буцаж ирж 15 хоног ажилна. Ажлынхаа тухай ярих их дуртай. Ажлын байранд удаан цагаар ажилуулдаггүй, аюулгүй ажиллагны дүрэм журам маш сайн мөрдөгддөг, хувцас хамгаалалтын хэрэгслийн хангалт хүн бүрт хангалттай хүрэлцээтэй, гуанзанд нь Ази, Европ монгол гурван орны хоолноос сонгож иддэг, хувцасаа тайлаад тавьчихсан байхад үйлчлэгч ирээд усаагаад өгдөг, хонодог байр нь шалнаасаа халаалттай дулаахан тохилог. Хэрвээ архи пиво тэнд заасан хэмжээнээс хэтрүүлж хэрэглэвэл шууд л хөөнө. Хятадууд Монголчуудыг дээрэлхэх байтугай бараг харагддаггүй цөөхөн байдаг гээд л их л бахархалтай жаргалтай ажлынхаа тухай ярьж гарна даа. Одоо би найздаа санаа зовохоо больсон. Харин найз минь л надад санаа зовдог болсон. Оюу Толгойгоос хотод ирж нэг хонохдоо намайг хоолонд оруулж, кино жүжиг үзүүлнэ, захаар цуг явж гэртээ баахан юм авна, намайг оюутан хүн гэж мөнгө өгнө тэгээд дорнодруу буцна.

Хаа хол зүүн аймагаас Оюу Толгойг 1300км зорьж очиж байна гэж бодохор тэнд ямар том хөрөнгө оруулалт, хөгжил дэвшил, маш өндөр цалинтай, хангамж сайтай, бүхий л талаараа сэтгэлд нийцсэн ажлын байр байгаа гэдэг нь ойлгомжтой. Хааяа би тамирчин болдог байж дээ гэж боддог. Хэрвээ багаасаа спортоор хичээллэсэн бол өдийд олимпын дэвжээнд ялалт байгуулж төрийнхөө далбааг өндөр өөд өргөн эх орныхоо эрдэнэсийн дээжээс энгэртээ зүүх завшаан олдох ч байсан юм бил үү. Гэхдээ харамсахгүй байна Оюу Толгойн үр ашгийн дээжийг монгол хүн бүр хүртэж байгаа болохоор хоёр мянган дамжсан Монголын хамгийн том бүтээн байгуулалт миний бид бүгдийн үр хүүхдэд ч мөн үр ашигаа өгсөөр байх болно гэдэгт итгэж байна.

Нийгмийн хариуцлагыг ухамсарласан олон талт үйл ажиллагаа явуулдаг Оюу Толгой-руу монголчууд минь бүү дайрч давшсаасй. Би С.Зоригийн нэгэн адил “Монгол хүний саруул ухаанд итгэдэг”.